

**Монголчуудын түүх”
номын зохиогч Ж.Куртины 1835-1906) тухай**

Америкийн иргэн Ж.Куртин Харвардын их сургуулийг 1863 онд төгсөж 1900 онд Монголын умард хэсгээр аялж үлэмж хэмжээний үлгэр домог, янз бүрийн хүний намтар, цадиг олж цуглуулсныг эдүгээ Харвардын их сургуульд хадгалж байна.

Ж.Куртин монголоор зорчихдоо өөрийн ажигласан, ном зохиолоос уншсан, сурвалжаас ашигласан зүйлдээ тулгуурлан монгол судлаачдын анхаарал татахуйц нилээд чамбай гурван бүтээл туурвиснаа сэрүүн тунгалаг ахуйдаа нийтийн хүртээл болгож амжаагүй аж. Гэвч гэргий нь түүний *“Монголчуудын түүх”, “Монголчууд Орост”, “Өмнөд Сибирьт аялсан нь: Монголчуудын шашин шүтлэг хийгээд шидэт үлгэр, домог хууч”* хэмээх гурван зохиолыг хэвлэлд бэлтгэж байхад нь буюу өнөөдрөөс яг зуун жилийн тэртээ тухайн үеийн АНУ-ын 26 дахь ерөнхийлөгч (1901-1909) Теодор Рузвельт (1858-1919) Ж.Куртины номд сонирхол татахуйц өмнөтгөл бичсэнийг би хэдэн жилийн өмнө Америкт байхдаа олж уншсан юм. Ерөнхийлөгч Т.Рузвельт уул өмнөтгөлдөө монголчуудын байлдан дагууллын талаар хэдийвээр хураангуй дурдсан боловч сайтар эргэцүүлбэл эдүгээ ч анхаарч үзүүштэй санаа авахуйц зүйл өгүүлжээ. Үүний сацуу ерөнхийлөгч өөрөө тухайн үед Монголын тухай ялангуяа Чингис хааны талаар нилээд сонирхож уншдаг, зохих мэдлэгтэй байсан нь түүний бичсэнээс илэрхий учир нэг ч болов монгол хүнд, ялангуяа эх түүхээ сонирхогчдод сонордуулахсан хэмээн санаж англи хэлний мэдлэг төдий л сайнгүйгээ мэдэх боловч тун хичээнгүйлэн монголчилсноо эрхэм аругай Танд өргөн барьж байна.

Жич: Ж.Куртин бол хэд хэдэн гадаад улсын хэл мэддэг, түүхч угсаатны зүйч, христийн шашин дэлгэрүүлэгч ер бусын ухаалаг хүн байсныг янз бүрийн толь бичигт өгүүлсэн байдгийг нуршин тайлбарлах нь илүүц буй за.

Харнууд Л.Ринчин
2007 оны 9 дүгээр сарын 1